

2. Хууль эрх зүйн орчин

Монгол улсын Засгийн газар сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг хөгжүүлэх ажлыг хөгжлийн тэргүүлэх чиглэлийн нэг болгохоор зааж, 2005 оны 6-р сарын 9-нд УИХ-аас Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2007 оны 1 дүгээр сарын 11-нд “Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль”-уудыг баталсан. Эрчим хүчний салбар тэр дундаа сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх зорилгын хүрээнд сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр суурилуулах, цахилгаан эрчим хүчний хэрэглээнд ашиглах иргэн, аж ахуйн нэгж, төр засгийн байгууллагуудын дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журмуудыг боловсруулж, үечилсэн бодлого стратеги гарган ажиллаж байгаа билээ.

2.1 Сэргээгдэх эрчим хүчний талаар баримтлах хууль тогтоомж

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрийн ашиглалт, хэрэгжүүлэлтийг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгчдэд тавигдах шаардлага, үйлдвэрлэгч/хэрэглэгч болон захиалагч/гүйцэтгэгчийн эрх үүргийн харилцааг зохицуулах хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжуудаас дурдвал:

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль:

Энэ хуулийн зорилт нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж цахилгаан, дулаан үйлдвэрлэж, нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хууль нь сэргээгдэх эрчим хүчний аль ч төрлийн эх үүсгүүрээр эрчим хүч үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд холбогдох баримт бичиг түүнд тавигдах шалгуур болон хуулийн этгээдийн эрх үүргийг тодорхойлон заасан эрх зүйн баримт бичиг юм.

Энэхүү хуулийн тогтоол нь 2007.01.11-ны өдөр батлагдсан бөгөөд 2015.06.19-ны өдөр сэргээгдэх эрчим хүчний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх бодлого боловсруулах, хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн цахилгааныг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, журмыг боловсруулж, батлах тухай зүйл заалттайгаар шинэчлэн найруулагдсан.

Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам:

Сэргээгдэх эрчим хүч(СЭХ)-ний эх үүсгүүр суурилуулсан иргэн, хуулийн этгээд нь СЭХ-ний үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчнээс өөрийн цахилгааны хэрэгцээгээ хангаж, хэрэгцээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг цахилгаан түгээх сүлжээнд нийлүүлэх тухай журмыг 2020 оны 8-р сарын 14-ны өдөр баталсан.

Цахилгаан эрчим хүчний сүлжээнд холбогдох цаашлаад эрчим хүч нийлүүлэхтэй холбоотой СЭХ-ний үүсгүүр эзэмшигчийн дагаж мөрдөх норм дүрэм, суурилуулах боломжит хүчин чадлын хэмжээ, сүлжээнд холбоход шаардагдах бичиг баримт болон талуудын эрх үүргүүдийг энэ баримт бичигт тусгасан.

Журамд зааснаар иргэн 20 хүртэл кВт-ын хүчин чадалтай үүсгүүр суурилуулах боломжтой бол хуулийн этгээд нь техникийн нөхцөлөөр тогтоосон хүчин чадлын 50%-аас хэтрэхгүй хүчин чадалтайгаар суурилуулах боломжтой юм.

Түгээх сүлжээнд холбогдох үүсгүүрийн зураг төсөл, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээг Тусгай зөвшөөрлийн 1.1 болон түүнээс дээш тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэн түгээх сүлжээний 0.4кВ-ын хүчдэлийн түвшинд холбоно.

Иргэн, хуулийн этгээд нь цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний тусгай гэрээнд тусгагдсан нөхцөлийг биелүүлснээр сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээс өөрийн хэрэгцээнээс илүү гарч үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх, хэрэглэх эрхээр хангагдана. Тусгай гэрээнд тусгагдсан нөхцөлүүдэд дараах зүйлс багтана. Үүнд:

- Үүсгүүрийн туршилт,
- Хэрэглэгчийн нийлүүлэх цахилгаан эрчим хүчний хэмжээ,
- Хэрэглэгчийн нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнээс хас тооцох нөхцөл,
- Тусгай техникийн нөхцөл,
- Батлагдсан ажлын зураг,
- Техникийн комиссын акт,
- Үүсгүүрийн ашиглалт, засвар
- Тоолуур, хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлага,
- Реле хамгаалалт, автоматикийн төхөөрөмж,
- Бусад холбогдох нөхцөл

Эх сурвалж: Эрчим хүчний сайдын 2020 оны 159 дүгээр тушаалын хавсралт

Төв, Өмнөд, Зүүн, Баруун, Алтай-Улиастайн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгаан эрчим хүчний тарифыг ЭХЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 390 дүгээр тогтоолоор баталсан.

Нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлсэн цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) дараах байдлаар тогтооно.

Хүснэгт 2 СЭХ-ний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгааны тариф

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Өдрийн цагаар /өглөөний 06:00 цагаас оройн 17:00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	140.18
2	Оргил ачааллын үед буюу оройн цагаар /оройн 17:00 цагаас шөнийн 22:00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	221.89

Эх сурвалж: ЭХЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 390 дүгээр тогтоолын хавсралт

✚ Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тогтоол:

Монгол улсын засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 198-р тогтоолоор сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийг гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-аас чөлөөлөхөөр баталсан. Хүснэгт 3-т гааль, НӨАТ-аас чөлөөлөгдөх тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийг харуулав.

Хүснэгт 3 Гааль, НӨАТ-аас чөлөөлөгдөх НЦҮ-ийн тоног төхөөрөмжийн жагсаалт

№	БТКУС-ийн код	Тоног төхөөрөмжийн нэр
2.10	7308.90.00	Нарны ойлгогч болон PV модуль суурилуулах зориулалттай төмөр тулгуур
2.17	7610.90.00	Нарны ойлгогч болон PV модуль суурилуулах зориулалттай хөнгөн цагаан тулгуур
2.28	8504.40.00	Инвертер, конвертер
2.29	8536.90.00	1000В-оос ихгүй хүчдэлийн холбогч, хуваарилагч хайрцаг
2.30	8537.10.00	1000В-оос ихгүй хүчдэлийн цахилгааны хяналт, удирдлагын төхөөрөмж
2.37	9028.30.00	Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тоолуур
2.38	9030.20.00	Осциллоскоп, осциллограф
2.43	9030.82.00	Нарны цахилгаан үүсгүүрийн чадал хэмжигч

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 198 дугаар тогтоолын хавсралт

Цахилгааны үнэ тариф:

Эрчим хүчний зохицуулах хороо (Эрчим хүчний зохицуулах хороо)-ны 2014 оны 231 дүгээр тогтоолын хавсралтаар цахилгаан эрчим хүчний үнэ тарифыг тогтоох аргачлалыг баталсан. Энэхүү аргачлалын зорилго нь цахилгаан, дулаан үйлдвэрлэх үнэ, диспетчерийн зохицуулалт хийх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний төлбөр, тариф, хэрэглэгчдэд худалдаах үнийг тогтооход оршино.

Монгол улс нь эрчим хүчний үндсэн 5 системтэй бөгөөд уг төсөл нь Улаанбаатарт хэрэгжиж байгаа тул цахилгаан эрчим хүчний хэрэглэгчид нь төв, зүүн, өмнөд бүсийн цахилгааны тарифаар бодож түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд хэрэглээний төлбөрөө төлнө. Төв, зүүн, өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг Хүснэгт 4-өөс үзнэ үү. Айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

Хүснэгт 4 Айл өрхөд борлуулах цахилгааны тариф

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Энгийн тоолууртай		
а	Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэлх хэрэглээ	Төг/кВт.ц	110.49
б	Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээших хэрэглээ	Төг/кВт.ц	130.29
2	2 тарифт тоолууртай		
а	Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	116.39
б	Орой, шөнийн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	Төг/кВт.ц	89.19
3	Сарын суурь тариф	Төг/сар	2,000.0

* Цахилгааны үнэ тариф нь хэрэглэгчийн тоолуурын ангиллаас хамааруулсан НӨАТ ороогүй дүн болно. Хэрэглэгч нь цахилгааны төлбөр тооцоог НӨАТ-тэй үнийн дүнгээр төлдөг бөгөөд энэ нь СЭХ-ний үүсгүүрээс түгээх сүлжээнд нийлүүлэх цахилгааны тариф болох 140.18төг/кВт.ц-тай дүйцнэ.

Эх сурвалж: Эрчим хүчний зохицуулах хороо, үнэ тариф

Тайлбар: Өдөр, орой, шөнийн тарифыг мөрдөх хугацааг тоолуурын цагаар тооцно.

Жич: Төв, Өмнөд бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 23.79 төг/кВт.ц-аар тооцно.

2.2 Сэргээгдэх эрчим хүчний талаар баримтлах төр засгийн бодлого

Ногоон хөгжлийн бодлого

“Ногоон хөгжлийн бодлого” 2016-2030 оны үйл ажиллагааны төлөвлөлтөд эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг тавин ажиллаж байна. Бодлогын хэрэгжүүлэлтийн стратегийн нэгт байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл хэрэгжүүлэх зорилт тавьсан ба үйл ажиллагааны төлөвлөгөөнд дурдагдсан сэргээгдэх эрчим хүчний төсөл хөтөлбөрүүдийг авч үзвэл:

- 2016-2023: Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эрх зүй, эдийн засгийн хөшүүргийн таатай орчин бүрдүүлж хэрэгжүүлэх
- 2016-2030: 10-50 МВт-ын хүчин чадал бүхий нарны цахилгаан станцын төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх,
- 2016-2030: 50-250 МВт-ын хүчин чадал бүхий салхин цахилгаан станцын төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх,
- 2016-2030: Томоохон гол мөрөн дээр усны хуримтлал бий болгож, олон зориулалтаар ашиглах усан цогцолбор байгуулах (Эгийн гол, Сэлэнгийн сав газарт 550МВт, Ховд голын сав газарт 150 МВт, Орхоны сав газарт 100 МВт),
- 2016-2030: Дулаан хангамж болон хэрэглээний халуун усны хангамжид сэргээгдэх эрчим хүчний технологи ашиглах оновчтой шийдлийг судлах, туршиж нэвтрүүлэх, дэмжиж урамшуулах

Эх сурвалж: Засгийн газрын 2016 оны 35 дугаар тогтоолын хавсралт

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого

I үе шат (2021-2030): Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгагдсан сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой зорилт, үйл ажиллагаанууд:

- Зорилт 2.5-ын хүрээнд: Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана
- Зорилт 4.2-ын хүрээнд: Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан чадлыг 30 хувьд хүргэнэ
- Зорилт 6.4-ын хүрээнд: Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.
- Зорилт 9.3-ын хүрээнд: Хот дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллыг төвлөрсөн, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжид холбон

сэргээгдэх эрчим хүчийг ашиглана. Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.

II үе шат (2031-2040): Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийн үе.

- Гэр хорооллын болон ногоон бүсийн айл өрхүүдийн эрчим хүчний хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт шилжүүлж, өрхийн үйлдвэрлэсэн цахилгааныг төвийн сүлжээнд нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

III үе шат (2041-2050): Орчин үеийн ухаалаг дэд бүтцийн сүлжээгээр эдийн засгийн хөгжлийг тэтгэх үе.

- Эрчим хүчний бие даасан нэгдсэн системтэй болж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг хоршин ашиглах ухаалаг тогтолцоонд шилжүүлж, эрчим хүч экспортлогч болсон байна.

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Шинэ сэргэлтийн бодлого:

“Шинэ сэргэлтийн бодлого” нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

Бодлогын хүрээнд хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх болно.

Эрчим хүчний эх үүсгүүрийг 2 дахин нэмэгдүүлэх эрчим хүчний сэргэлт багцыг хэрэгжүүлэхэд дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.
- Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.
- Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.
- Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.
- Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолойг барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

Эх сурвалж: Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

2.3 Барилга байгууламжийн дээвэр дээр нарны цахилгаан үүсгүүр суурилуулахад дагаж мөрдөх хууль тогтоомж

Нарны эрчим хүчний үүсгүүр нь бусад төрлийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүдтэй харьцуулахад хот, хөдөө, барилга, уул, тал газар зэрэг хаана ч суурилуулах боломжтой, засвар үйлчилгээ хийхэд энгийн. Барилга байгууламж, орон сууц төвлөрсөн хот суурин газар нарны цахилгаан үүсгүүр суурилуулах газар учир дээврийн талбайг ашиглан суурилуулах тохиолдол түгээмэл болсон.

Барилгын салбар нь Монгол Улсын дулааны эрчим хүчний 56%, цахилгаан эрчим хүчний 38%-ийг хэрэглэж хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) ойролцоогоор 30%-ийг бүрдүүлдэг байна.

Монгол улсын хэмжээнд барилга байгууламжийн дээвэр эсхүл хананд нарны цахилгаан үүсгүүр суурилуулахад дагаж мөрдөх тусгайлан заасан хууль тогтоомж байхгүй хэдий ч барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн хурлаар “Барилга байгууламжид эрчим хүчний гэрчилгээ олгох журам”-ыг хэлэлцэж, зөвлөлийн гишүүдийн саналаар дэмжигдсэн. Энэхүү журам хэрэгжсэнээр

- Шинээр баригдаж буй барилга байгууламжид зураг төслийн шатнаас эрчим хүчний хэрэглээ, үр ашгийн үзүүлэлтийг тогтоох боломж бүрдэх, хэрэглэгч болон ашиглагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөх;
- Ногоон барилгын үнэлгээний системийг нэвтрүүлэх нөхцөл бүрдэх;
- Ногоон зээлийн санхүүжилтийн тогтолцоо хөгжих;
- Барилга байгууламжийн ашиглалтын зардал буурч, эрчим хүчийг хэмнэснээр хүлэмжийн хийн ялгаруулалт багасах, байгаль орчны бохирдол багасах

зэрэг үр дүнгүүд гарах ба амьдрах орчин сайжрах юм.

Хөгжингүй улс орнууд болох Герман, Америк, Оросын Холбооны улс, Хятад зэрэг томоохон орнууд 1970 оноос эхлэн эрчим хүчний үр ашгийн үзүүлэлтэд шаардлага, шалгууруудыг тавьж барилга байгууламжид эрчим хүчний хэрэглээний гэрчилгээг олгож эхэлсэн.

Сүүлийн жилүүдэд барилга байгууламжийн дээвэр болон хананд нарны эрчим хүчний үүсгүүр суурилах боломж, үр ашгийн талаар их сургуулийн багш судлаачид, судалгаа шинжилгээний байгууллагууд ихээхэн ач холбогдол өгч байгаа. Энэ төрлийн эрчим хүчний үүсгүүр нь иргэн, үйлчилгээний барилга байгууламжийн дээврийн талбайд хэдийн суурилагдан сүлжээнд холбогдон ажиллаж байгаа билээ.

Нарны цахилгаан үүсгүүрийг дээвэр, хананд суурилуулахдаа дээвэр/хананы бүтэц, шинж чанарт тохирсон зориулалтын суурь ашиглан бат бөх байдлыг бүрэн хангаж, барилга байгууламжийн ашиглалтад сөргөөр үл нөлөөлөхүйцээр битүүмжлэлийг чанарын өндөр түвшинд хийснээр барилга нь зөвхөн эрчим хүчний хэрэглэгч байгаад зогсохгүй, нийлүүлэгч болох боломжтой юм.